



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/599

Мөрөн сум

Төсөвт зохицуулалт хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 42 дугаар зүйлийн 42.2.1, 65 дугаар зүйлийн 65.1.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хурлын 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг дарга ерөнхий дансанд батлагдсан “Хөдөө аж ахуйн чиглэлээр гадаадад үзэсгэлэн худалдаанд оролцох зардал”-ын үлдэгдэл 29,000.000 (Хорин есөн сая төгрөг)-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/59 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган үүднээс зохион байгуулах “Органик Хөвсгөл-Органик мах” арга хэмжээний зардалд шилжүүлсүгэй.

2. Зардал хоорондын зохицуулалтыг хийж, зарлагын сарын хуваарьт тусгаж батлуулан, мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ